

**Хоёрдогч өглөгийн хүүгийн нөхцөлийг тогтоож,
гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дэх заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20, 9.6.23 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулагдсан Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”)-ын 25/05 тоот шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ын 2.2.2 дахь заалт, 3.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн АХ-25/08 тоот дүгнэлт болон 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ХЭЭБХ-аар Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор “АНД Системс” ХХК-иас 3 (гурав) сая ам.доллартай тэнцэх төгрөгийг хоёрдогч өглөг хэлбэрээр авч, Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, тус хоёрдогч өглөгийн хүүг тогтоох, гэрээ байгуулах эрх олгох болон эдгээртэй холбогдон үүсэх бусад асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхийг Компанийн ТУЗ-д олгосныг дурдсугай.
2. Иймд энэхүү Тогтоолын 1 дэх хэсэгт дурдсаны дагуу “АНД Системс” ХХК-тай байгуулах Хоёрдогч өглөгийн гэрээний хүүг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Компанийн ХЭЭБХ-ын 25/05 тоот шийдвэр болон энэхүү Тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд “АНД Системс” ХХК-тай холбогдох гэрээ, хэлцлийг байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, үр дүнг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

